



“МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 26/07

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, “Монгол шуудан” ХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2025 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангаарх цэвэр ашгийн дүнгээс 31.6 хувиар тооцож нийт 149,379,544.50 (нэг зуун дөчин есөн сая гурван зуун далан есөн мянга таван зуун дөчин дөрвөн төгрөг тавин мөнгө) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахыг зөвшөөрсүгэй.

2. Нэгж хувьцаанд 1.50 (нэг төгрөг тавин мөнгө) төгрөгийн ногдол ашиг тараахыг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д үүрэг болгосугай.

3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2026 оны 04 дугаар сарын 31-ний өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан тараасугай.

5. Ногдол ашиг хуваарилалтын шийдвэр болон ногдол ашиг тараасан талаарх тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Д.Балдорж)-нд үүрэг болгосугай.

6. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 26/02 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ